

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2026/136/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2026 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.05 № 01/52.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бараа материал данс өмнөх оноос 45,431.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр галын аюулгүй байдлын булан байгуулахад 9,000.0 мянган төгрөгийн хангамжийн материал, байгууллагын хэрэгцээнд бага үнэтэй түргэн элэгдэх 7,355.7 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан, аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны А/04-А/95 дугаар тушаалуудаар 27,497.3 мянган төгрөгийн **"өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарт ашиглалтын гэрээгээр ашиглуулах"** хөрөнгүүдийг шилжүүлсэнтэй холбоотой өсөлт байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 26,428.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 16,151.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Жаргалант сумын ЗДТГ нь тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт 56 арга хэмжээний хүрээнд 96 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>244,078,564.53</u></b>	<b><u>306,712,729.53</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	16,978,200.00	7,581,200.00
<b>33100</b>	Ажиллагчидтай холбогдсон авлага	16,827,981.00	7,430,981.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	150,219.00	150,219.00
<b>3351</b>	Байгууллагаас авах авлага	150,219.00	150,219.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	192,000,364.53	238,581,529.53
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11,023,400.00	11,023,400.00
<b>35130</b>	Эм боох материал	11,023,400.00	11,023,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	154,976,964.53	227,558,129.53
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	62,500.00	2,863,500.00
<b>35420</b>	Аж ахуйн материал	7,156,480.00	12,867,630.00
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	147,757,984.53	211,826,999.53
<b>35600</b>	Мал амьтад	26,000,000.00	00.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	35,100,000.00	60,550,000.00
<b>36300</b>	Тэжээлийн нөөц	35,100,000.00	60,550,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,072,856,082.44</u></b>	<b><u>4,412,672,050.74</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,072,856,082.44	4,412,672,050.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,963,283,445.64	4,292,249,413.94
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	3,693,002,202.00	3,760,886,326.00
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	-656,447,508.77	-674,843,814.84
<b>39203</b>	Авто-тээврийн хэрэгсэл	799,717,366.00	990,395,366.00
<b>39204</b>	Хуримтлагдсан элэгдэл	-233,677,243.39	-309,400,807.02
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж (компьютер)	226,610,550.40	196,000,560.73
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	-118,373,269.84	-73,447,754.56
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,315,357.22	36,394,500.00
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	-22,462,212.18	-6,527,104.43
<b>39209</b>	Зам, гүүрийн байгууламж	60,720,000.00	83,120,000.00
<b>39210</b>	Хуримтлагдсан элэгдэл	-20,198,999.85	-32,092,999.70
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	302,608,510.50	357,495,922.00
<b>39215</b>	Хуримтлагдсан элэгдэл	-112,795,494.28	-35,994,968.07
<b>39217</b>	Ном	264,187.83	264,187.83
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	109,572,636.80	120,422,636.80
<b>39301</b>	Програм хангамж	2,967,000.00	1,350,000.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	-2,967,000.00	00.00
<b>39303</b>	Бусад биет бус хөрөнгө	109,572,636.80	119,072,636.80
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,316,934,646.97</u></b>	<b><u>4,719,384,780.27</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,600,000.00</u></b>	<b><u>65,521,932.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,600,000.00	65,521,932.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,600,000.00	65,521,932.00
<b>41320</b>	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	18,543,662.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	5,600,000.00	46,978,270.00
<b>41361</b>	Байгууллагад төлөх өглөг	5,600,000.00	40,577,270.00
<b>41362</b>	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	6,401,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,311,334,646.97</u></b>	<b><u>4,653,862,848.27</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,311,334,646.97	4,653,862,848.27
<b>511</b>	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,010,256,554.27	3,010,256,554.27
<b>51101</b>	Өмч: - төрийн	3,010,256,554.27	3,010,256,554.27
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,107,978,778.38	1,541,284,918.63
<b>51210</b>	Өмнөх үеийн үр дүн	1,107,978,778.38	1,198,756,717.33
<b>51220</b>	Тайлант үеийн үр дүн	00.00	342,528,201.30
<b>51300</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,099,314.32	102,321,375.37
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,316,934,646.97</u></b>	<b><u>4,719,384,780.27</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,490,995,824.25</b>	<b>1,817,466,193.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,073,435,813.25</b>	<b>736,625,776.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,073,435,813.25	736,625,776.93
<b>120004</b>	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,073,435,813.25	736,625,776.93
<b>120017</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,019,460,180.00	665,156,461.93
<b>120018</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	53,975,633.25	71,469,315.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,417,560,011.00</b>	<b>1,080,840,417.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	119,585,111.00	50,406,117.00
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,787,530.00	7,024,061.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,797,581.00	43,382,056.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,297,974,900.00	1,030,434,300.00
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,297,974,900.00	1,030,434,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,603,806,124.78</b>	<b>1,474,147,707.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,603,806,124.78</b>	<b>1,474,147,707.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,410,047,448.47	1,396,292,118.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	644,310,884.73	689,644,215.78
<b>210101</b>	Үндсэн цалин	442,894,910.48	458,437,304.91
<b>210102</b>	Нэмэгдэл	191,297,074.25	227,943,210.87
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,263,700.00
<b>210104</b>	Урамшуулал	10,118,900.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,491,207.96	85,393,799.07
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	51,061,830.08	58,067,575.37
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	9,189,733.67	6,831,655.97
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	3,227,218.62	3,415,727.94
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	3,892,412.82	3,415,727.94
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	12,120,012.77	13,663,111.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,101,807.00	55,169,547.00
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	16,026,655.00	18,579,147.00
<b>210302</b>	Түлш, халаалт	38,075,152.00	36,590,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	49,204,888.00	117,961,784.00
<b>210401</b>	Бичиг хэрэг	3,735,000.00	5,315,100.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	30,179,518.00	31,324,132.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,445,000.00	4,078,000.00
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,625,720.00	8,476,552.00
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,219,650.00	929,000.00
<b>210408</b>	Бараа материал акталсны зардал	00.00	67,839,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,067,940.00	1,340,000.00
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,340,000.00
<b>210604</b>	Урсгал засвар	38,067,940.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,775,747.00	4,110,500.00
<b>210702</b>	Дотоод албан томилолт	4,775,747.00	4,110,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	196,098,409.00	59,716,214.00
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,575,468.00	57,143,540.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	222,674.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	550,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,170,000.00	00.00
210807	Газрын төлбөр	1,343,341.00	00.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	343,996,564.78	382,956,058.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,764,251.00	28,209,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	7,196,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,232,313.78	347,550,208.88
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	193,758,676.31	77,855,589.15
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	70,695,100.00	3,044,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,086,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,609,000.00	3,044,500.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	123,063,576.31	74,811,089.15
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>887,189,699.47</b>	<b>343,318,486.05</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	790,284.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	790,284.75
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-790,284.75
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>887,189,699.47</b>	<b>342,528,201.30</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,412,432,030</b>	<b>1,090,237,417</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,412,432,030</b>	<b>1,090,237,417</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	114,457,130	59,803,117
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,787,530	7,024,061
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,669,600	52,779,056
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,297,974,900	1,030,434,300
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,297,974,900	1,030,434,300
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,363,039,030</b>	<b>1,067,237,417</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,363,039,030</b>	<b>1,067,237,417</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,169,280,354</b>	<b>989,381,828</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	644,310,885	689,644,216
210101	Үндсэн цалин	442,894,910	458,437,305
210102	Нэмэгдэл	191,297,074	227,943,211
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,263,700
210104	Урамшуулал	10,118,900	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	79,491,208	85,393,799
210201	Тэтгэврийн даатгал	53,849,587	58,067,575
210202	Тэтгэмжийн даатгал	6,401,976	6,831,656
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,227,219	3,415,728
210204	Ажилгүйдлийн даатгал	3,892,413	3,415,728
210205	Эрүүл мэндийн даатгал	12,120,013	13,663,112
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,101,807	59,169,547

210301	Гэрэл, цахилгаан	16,026,655	18,579,147
210302	Түлш, халаалт	38,075,152	40,590,400
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,724,888	33,202,542
210401	Бичиг хэрэг	3,700,000	3,316,600
210402	Тээвэр, шатахуун	30,179,518	20,432,950
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,445,000	4,198,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,625,720	2,325,992
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,774,650	2,929,000
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,807,940	3,840,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,840,000
210604	Урсгал засвар	38,807,940	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	4,775,747	4,110,500
210702	Дотоод албан томилолт	4,775,747	4,110,500
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	174,112,409	59,399,294
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	168,589,468	56,826,620
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000	1,800,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000	222,674
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000	550,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,170,000	-
210807	Газрын төлбөр	1,343,341	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	122,955,470	54,621,930
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,955,470	53,121,930
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,500,000
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,758,676</b>	<b>77,855,589</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	70,695,100	3,044,500
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,086,100	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,609,000	3,044,500
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	123,063,576	74,811,089
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,063,576	74,811,089
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>49,393,000</u></b>	<b><u>23,000,000</u></b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>49,393,000</b>	<b>23,000,000</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>49,393,000</b>	<b>23,000,000</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	49,393,000	23,000,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,393,000	23,000,000
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(49,393,000)</u></b>	<b><u>(23,000,000)</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,010,256,554.3	195,843,619.1	218,044,774.2	3,424,144,947.5
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,010,256,554.3</b>	<b>195,843,619.1</b>	<b>218,044,774.2</b>	3,424,144,947.5
<b>C07</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	887,189,699.5	887,189,699.5
<b>C08</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,010,256,554.3</b>	<b>193,099,314.3</b>	<b>1,107,978,778.4</b>	4,311,334,647.0
<b>D02</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	90,777,939.0	90,777,939.0
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,010,256,554.3</b>	<b>193,099,314.3</b>	<b>1,198,756,717.3</b>	4,402,112,585.9
<b>D04</b>	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(90,777,939.0)	-	(90,777,939.0)
<b>D08</b>	Тайлант үеийн үр дүн	-	-	342,528,201.3	342,528,201.3
<b>D09</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,010,256,554.3</b>	<b>102,321,375.4</b>	<b>1,541,284,918.6</b>	4,653,862,848.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,089,729,100	981,089,108	108,639,992	90
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,089,729,100	981,089,108	108,639,992	90
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,083,377,100	978,044,608	105,332,492	90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	694,157,900	689,644,216	4,513,684	99
<b>210101</b>	Үндсэн цалин	557,755,800	458,437,305	99,318,495	82
<b>210102</b>	Нэмэгдэл	132,572,100	227,943,211	(95,371,111)	
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	3,830,000	3,263,700	566,300	85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	87,099,400	85,393,799	1,705,601	98
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	59,227,600	58,067,575	1,160,025	98
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	6,968,000	6,831,656	136,344	98
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	3,483,900	3,415,728	68,172	98
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	3,483,900	3,415,728	68,172	98
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	13,936,000	13,663,112	272,888	98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62,178,200	59,169,547	3,008,653	95
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	20,908,200	18,579,147	2,329,053	89
<b>210302</b>	Түлш, халаалт	41,270,000	40,590,400	679,600	98
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	47,321,000	29,865,822	17,455,178	63
<b>210401</b>	Бичиг хэрэг	5,000,000	3,316,600	1,683,400	66
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	27,000,000	17,246,230	9,753,770	64
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,450,000	4,048,000	402,000	91
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,535,000	2,325,992	3,209,008	(58)
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,336,000	2,929,000	2,407,000	55
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,206,700	-	3,206,700	(100)
<b>210503</b>	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,206,700	-	3,206,700	(100)
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,840,000	3,840,000	-	100
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	3,840,000	3,840,000	-	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,000,000	2,910,000	3,090,000	49
<b>210702</b>	Дотоод албан томилолт	6,000,000	2,910,000	3,090,000	49
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	105,789,200	78,399,294	27,389,906	74
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,906,900	75,826,620	24,080,280	76
<b>210802</b>	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600	-	1,209,600	(100)
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	1,800,000	1,800,000	-	100
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	222,700	222,674	26	100
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	550,000	550,000	-	100
<b>210806</b>	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000	-	600,000	-
<b>210807</b>	Газрын төлбөр	1,500,000	-	1,500,000	(100)
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	73,784,700	28,821,930	44,962,770	39

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,284,700	27,321,930	13,962,770	66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,500,000	1,500,000	31,000,000	5
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,352,000	3,044,500	3,307,500	48
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,352,000	3,044,500	3,307,500	48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,352,000	3,044,500	3,307,500	48
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,089,729,100	981,089,108	108,639,992	90
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,089,729,100	981,089,108	108,639,992	90
132001	Орон нутгийн төсвөөс	1,089,729,100	981,089,108	108,639,992	90
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	-
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28	28	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21	-	100
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100
620004	Гэрээт ажилтан	4	4	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,803,117</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>59,803,117</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,337,220</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,336,720
210402	Тээвэр, шатахуун	3,186,720
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,200,500
210702	Дотоод албан томилолт	1,200,500
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,000,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25,800,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,800,000
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	25,465,897
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	25,465,897
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>59,803,117</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>59,803,117</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,024,061
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,779,056
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,917.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад тус 3 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд зарцуулсан 20,542.2 мянган төгрөгийн бараа материалын хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө."* гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Хөрөнгийн ашиглалтын жилийг буруу оруулснаас тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 176.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон байна. Энэ нь НБББББ-ийн 5.4 Үндсэн хөрөнгө хэсгийн 7 дугаарт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг баримтлаагүй, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Хангамжийн материалын шинжтэй 3,199.0 мянган төгрөгийн бараа материалыг барилгын засварын материал дансанд бүртгэсэн байна.

Аудитаар нийт 26,428.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 16,151.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт хүргүүлсэн.

### **5.1 Албан шаардлага**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас **биеийн тамирын арга зүйч** ажиллуулж, цалин, шимтгэл, татварын зардалд нийт 10,277.5 мянган төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны аудитаар үндсэн орон тоонд ажиллуулсан байсныг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь хэсэгт *"батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох,"*, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар баталсан *"Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай"* тушаалын хоёрдугаар хавсралтад заасан *"Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"* хэсгийн **2801-Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж** бүлгийн тайлбарт *"Байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. ...Хамаарахгүй зүйлс: Хувь хүнд ажил үйлчилгээ авсны төлөөсөнд олгож байгаа НДШ тооцогдох цалин хөлс, урамшуулал"* гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлага барагдуулахтай холбоотой:**

**Илрүүлэлт:** Буруутай шийдвэр гаргасан нь шүүхийн шийдвэрээр нотлогдож, иргэнийг хохиролгүй болгосон нийт 5,127.9 мянган төгрөгийн авлага байна. Уг авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дээрх авлагыг 2026 онд багтаан барагдуулах арга хэмжээ авч, төсвийг хохиролгүй болгох

#### **2. Хугацаа дууссан бараа материалын үлдэгдэлтэй холбоотой:**

**Илрүүлэлт:** Бараа материалын тайланд 11,023.4 мянган төгрөгийн үнэтэй ковидын үед нөөцийн зориулалтаар бэлтгэсэн эм боох материалын үлдэгдэл байна. Уг бараа материалын ашиглах хугацаа дууссан бөгөөд хөрөнгийн тооллогоор ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"Үйл"*

ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах” гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахад хадгалаатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг томилж, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг олж тогтоон нэр төрөл, үнэ, хэзээ хаанаас авсан зэрэг мэдээлэл бүхий жагсаалт үйлдэж, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар”-ын дагуу хугацаа дууссан тэмдэг тэмдэглэгээ хийж тусгаарлан, устгалыг журмын дагуу шийдвэрлэх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон	1	176.3			1	176.3				
Бараа материалын ангилал буруу бүртгэсэн	1	3,199.0			1	3,199.0				
Бараа материалын зарлагын хөдөлгөөн бүртгээгүй	1	20,542.2	1	20,542.2						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>23,917.5</b>	<b>1</b>	<b>20,542.2</b>	<b>2</b>	<b>3,375.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗЕХ-ийн 103-тай холбоотой авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй	1	5,127.9					1	5,127.9
Хугацаа дууссан БМ устгаагүй	1	11,023.4					1	11,023.4
Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	1	10,277.5			1	10,277.5		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>26,428.8</b>			<b>1</b>	<b>10,277.5</b>	<b>2</b>	<b>16,151.4</b>